



"Багануур" ХК-ийн ТУЗ-ийн 2012 оны
тоот 20 тоолын хавсралт №

"БАГАНУУР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.

1.1."Багануур" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид ТУЗ гэх) нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд Компанийн тухай хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн дүрмийн хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2."Багануур" ХК-ийн хэтийн болон ойрын үеийн бодлого зорилтыг тодорхойлох, тогтвортой, ашигтай үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэхтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлыг зарлах, бэлтгэлийг хангах, зохион байгуулах, тогтоол шийдвэр гаргах, биелэлтэд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах, гишүүдээ байнгын болон тодорхой хугацаагаар ажил хариуцуулан гүйцэтгэлийг хянах, хариуцлага хүлээлгэх зэрэгт энэхүү журмыг мөрдөнө.

1.3.ТУЗ-ийн төрийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа гишүүд нь хэлэлцэж буй асуудалд ажил хэрэгч, идэвхи санаачлагатай, үнэнч шударгаар хандан, зохих хууль тогтоомжийн хүрээнд Төрийн өмчийн хороо /цаашид ТӨХ гэх/-ноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу компанийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргаж ажиллана. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь хяналтын багцыг эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагын нөлөөнд авталгүй нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэн Компанийн тухай хууль, компанийн дүрэм, холбогдох бусад хууль тогтоомийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.4.Шинээр гарсан хууль, тогтоомж болон удирдах дээд байгууллагын тогтоол, шийдвэр, компанийн дүрэмд өөрчлөлт орсон тухай бүр түүнд нийцүүлэн энэ журамд зохих нэмэлт өөрчлөлтийг оруулна.

ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2.1 ТУЗ-ийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна.

2.2. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, хурал хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ. ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн хурлаас шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

2.3. ТУЗ-ийн зардлыг компанийн жил бүрийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинд тусган хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулна.

2.4. ТУЗ нь орон тооны бус нарийн бичгийн даргатай байх бөгөөд /цаашид нарийн бичгийн дарга гэх/ ТУЗ-ын даргын санал болгосноор ТУЗ томилно.

2.5. Нарийн бичгийн дарга нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- компанийн дүрмэнд заасан бичиг баримтыг бүрдүүлэх, хадгалах ажлыг хариуцаж, түүний хэрэгжилтэнд хяналт тавих
- ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар ТӨХ-ны удирдамжийг тухай бүр авч төрийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа гишүүдэд танилцуулах

- компанийн ажилтнууд болон хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан санал хүсэлт, гомдлыг хүлээн авч бүртгэн ТУЗ-д танилцуулж хариу өгөх

- ТУЗ-ийн гишүүдийг компанийн үйл ажиллагааны мэдээллээр тогтмол хангаж ажиллана.

- ТУЗ-өөс компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан "хөлсөөр ажиллах гэрээ"-ний биелэлтийг хагас, бүтэн жилээр гүйцэтгэх захирлаар гаргуулж ТУЗ-ийн хуралд танилцуулна.

- ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг ил тод нээлттэй байлгаж, хувьцаа эзэмшигчид, ажиллагсдад танилцуулах ажлыг зохион байгуулах

2.6. ТУЗ-ийн дарга шаардлагатай гэж үзвэл компанийн бизнес төлөвлөгөө батлах, төсөл хэрэгжүүлэх, эзэл авах, үндсэн хөрөнгө авах, данснаас хасах, хөрөнгө оруулалт хийх, охин компани, салбар нэгж байгуулах зэрэг ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулахтай холбогдсон асуудал, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хурлаар хэлэлцэхдээ ажлын хэсэг байгуулан нарийвчлан судалж санал дүгнэлт гаргасны үндсэн дээр шийдвэр гаргаж болно.

2.7. ТУЗ нь дэд хороод болон гишүүдэд тодорхой хариуцах ажил, үүргийн хувиар гарган өгч, компанийн аппаратын үйл ажиллагаанд хяналт тавих, хуралд бэлтгэх, шийдвэрийн биелэлтийг хангуулах судалгаа, дүгнэлт гаргах зэрэг үр нөлөө бүхий арга хэлбэрийг ашиглаж ажиллана.

2.8. ТУЗ нь жилийн ажлын тайлангаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тавьж хэлэлцүүлэн үнэлэлт, дүгнэлт гаргуулна.

ГУРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

3.1. ТУЗ-ийн ээлжит хурлыг сард нэг удаа хуралдуулна. Хурлын товыг ТУЗ-ийн дарга товлож, нарийн бичгийн дарга бэлтгэлийг хангана. Зарласан ээлжит хурлыг урьдчилан тохиролцож хойшлуулж болно.

3.2. Шаардлагатай гэж үзвэл тухайн сард ээлжит бус хуралдааныг ТУЗ-ийн дарга, гишүүн, компанийн гүйцэтгэх удирдлагын санаачлага, шаардлагаар хуралдуулж болно. Хурлыг санаачлагч нь нарийн бичгийн даргатай хамтран хурлын бэлтгэлийг хангана. ТУЗ-ийн хурлыг өргөтгөсөн хэлбэрээр хуралдаж болно.

3.3. ТУЗ-ийн гишүүд саналаа эчинээ өгч ажлын журмаар шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд нарийн бичгийн дарга ТУЗ-ийн даргын зөвшөөрлөөр гишүүдээс санал авч дүнг гаргах бөгөөд ТУЗ-өөс гарах шийдвэрт гишүүн бүрийн өгсөн саналыг хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлд бичнэ.

3.3. ТУЗ-ийн хурал /цаашид хурал гэх/-аар ТУЗ-ийн даргын баталж, урьдчилан тараасан материал, танилцуулга, шийдвэрийн төсөлтэй асуудлыг хэлэлцэнэ.

3.4. Хурлаар хэлэлцэх асуудлыг компанийн ажил хариуцсан ажилтан ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай хамтран бэлтгэж, холбогдох материал /судалгаа, тооцоо, гэрээ, хэлэлцээр, түүний биелэлт болон бусад зүйл/-ыг хавсаргах бөгөөд гүйцэтгэх захирал холбогдох албан тушаалтан гарын үсэг зурж тэмдэг дарж баталгаажуулсан байна.

3.5. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг хуралдах өдрөөс 2-оос доошгүй хоногийн өмнө гишүүдэд нарийн бичгийн дарга хүргэсэн байна. Компанийн бизнесийн нууцтай холбоотой болон хувилж олшруулахад техник ажиллагаа ихээхэн шаардсан материалыг гишүүд компани ирж танилцан саналаа бэлтгэж болно.

3.6. ТУЗ-ийн хурал гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно.

3.7. Хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. Хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

3.8. Тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүн санал өгөх эрхгүй байвал шийдвэрийг саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.9. Хурлын шийдвэрийн хэлбэр нь тогтоол байна. Тогтоолыг ТУЗ-ийн албан бланк дээр хэвлэн, ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарна. Компанийн болон ТУЗ-ийн дотоод асуудалтай холбоотой, түүнчлэн тухайн хурал дээр шийдвэрлэх боломжгүй, судлах шаардлагатай асуудал гарвал “ТУЗ-ийн хурлын тэмдэглэлээс” гэсэн хэлбэртэй шийдвэр гаргаж болно.

3.10. Хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх ба аудио, видео техник ашиглан хийж болно. ТУЗ-ийн дарга хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлтэй танилцаж гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

3.11. Хурлаар асуудал хэлэлцэхдээ дараах дэгийг баримтлана.

-Асуудлыг компанийн гүйцэтгэх захирал эсвэл тухайн ажил хариуцсан эрх бүхий албан тушаалтан танилцуулна.

-ТУЗ-ийн гишүүд асууж танилцана.

-ТУЗ-ийн гишүүд санал гаргана.

-Хурал даргалагч ТУЗ-ийн саналд үндэслэн ТУЗ-өөс гаргах шийдвэрийн төслийг томъёолно.

-Санал хурааж ТУЗ-өөс гарах шийдвэрийн төслийг баталгаажуулна.

3.12. Хурлаас гарсан шийдвэрийн нэг хувийг компанийн захиргаанд нарийн бичгийн дарга хүлээлгэн өгнө.

3.13. Гишүүд хуралд биеэр оролцох үүрэгтэй. Хурлын зарлал хүлээн авсан боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралд оролцоогүй гишүүнийг тасалсанд тооцох ба тухайн сарын цалингийн 50 хүртэл хувийг ТУЗ-ийн даргын шийдвэрээр хасаж болно. Биеэр хүрэлцэн ирэх боломжгүй гишүүн хуралд бичгээр санал өгч болох бөгөөд энэ тохиолдолд түүнийг хуралд оролцсонд тооцно. Нэг гишүүн 2-оос дээш хуралд бичгээр санал ирүүлэхийг хориглоно.

3.14. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд 3, ба түүнээс дээш удаа, эсвэл тухайн жилд хийсэн хурлын 50 хувьд биеэр оролцоогүй, ТӨХ-ноос баталсан удирдамж, чиглэлийг баримтлаагүй Төрийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа гишүүнийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 6 дахь заалтын дагуу өөрчлөх саналыг ТУЗ-ийн дарга хувьцаа эзэмшигчдийн хуралд тавьж шийдвэрлүүлнэ.

ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО БА ХАРААТ БУС ГИШҮҮН

4.1. ТУЗ нь тус бүр гурван хүний бүрэлдэхүүнтэй аудитын байнгын хороотой байх бөгөөд шаардлагатай гэж үзвэл цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороодыг байгуулж болно. Эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

4.2. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4-т заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.

4.3. Нэр дэвшүүлэх хороо нь “Компанийн тухай” хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5-д заасан бүрэн эрхийг, цалин урамшууллын хороо нь мөн хуулийн 81.6-д заасан үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллана.

4.4. Аудитын хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж ажлын тайлангаа ТУЗ-д танилцуулж байх бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу хяналт, шалгалтын ажлыг гүйцэтгэнэ.

4.5. Хараат бус гишүүн нь “Компанийн тухай” хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 –д заасан шалгуурыг хангаж нэр дэвшүүлэх хорооноос хувьцаа эзэмшигчдийн хуралд нэрийг нь дэвшүүлэн сонгогдсон хүн байна.

4.6. Хараат бус гишүүн нь мөн хуулийн 79 дүгээр зүйлд заасны дагуу эрх, үүргээ хэрэгжүүлнэ.

Энэхүү журмаар зохицуулаагүй аливаа асуудлыг тухайн үед ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, хууль эрх зүйн актад нийцүүлэн шийдвэрлэж болно.

Энэхүү журам нь ТУЗ-ийн хурлаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

---000---



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 13

Багануур

Г “БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН Г
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

Нэг.Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон нийт 13-н гишүүдийн 93%-ийн
санал авсан Бямба овогтой Ариунболдыг “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
даргаар сонгосугай.

ГИШҮҮД:



Б.АРИУНБОЛД

ДАРТАГ

Д.БОЛД

М.ХУЯГБААТАР

Г.МЭРГЭНБАЯР

Д.НАРАНГЭРЭЛ

Л.ОЮУНЧИМЭГ

О.БОЛОР ЭРДЭНЭ

Г.БАТДОРЖ

Г.ЁНДОНГОМБО

Б.ӨСОРГАРАВ

Т.НАРАН

Б.ГАНБАТ



**“НАКО ТҮЛШ” ХК – ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 сарын 16 өдөр

Дугаар 6

Улаанбаатар

Г

Г

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 78.1-р заалт болон “Нако Түлш” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Нако Түлш” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн **Б.Батбаатарыг** томилсугай.

ЗӨВШӨӨРСӨН:



_____ Б.БАТБААТАР

_____ Б.БАЯРБАТ

_____ ГРАМ ЧЭПМЭН

_____ Д.ДАЯНБИЛГҮҮН

_____ Б.ЛХАГВАДОРЖ

_____ Ж.ЭРДЭМБИЛЭГ

_____ Д.ТҮВШИНТӨГС

_____ Д.НАРАНГОО

_____ Т.ТАМИР



**“НАКО ТҮЛШ” ХК – ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 сарын 16 өдөр

Дугаар 7

Улаанбаатар

Г

Г

Гүйцэтгэх захирал томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76.1.8-р заалт болон “Нако түлш” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Нако түлш” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар **Б.Баярбатыг** үргэлжлүүлэн ажиллуулж, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээг шинээр баталсугай..

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БАТБААТАР



**“НАКО ТҮЛШ” ХК – ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 сарын 16 өдөр

Дугаар 8

Улаанбаатар

Г

Г

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх дэд хороодыг томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 81.2 заалт болон “Нако Түлш” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Нако Түлш” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын дэд хорооны даргаар **Т.Тамир**, гишүүдээр **Д.Даянбилгүүн**, **Д.Нарангоо** нарыг томилсугай.
2. Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар **Ж.Эрдэмбилэг**, гишүүдээр **Т.Тамир**, **Д.Нарангоо** нарыг томилсугай.
3. Цалин урамшууллын дэд хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн **Грам Чэпмэн**, гишүүдээр **Т.Тамир**, **Д.Түвшинтөгс** нарыг томилсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Б.БАТБААТАР



**“НАКО ТҮЛШ” ХК – ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 сарын 16 өдөр

Дугаар 9

Улаанбаатар

Г

Г

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 82.1 заалт болон “Нако Түлш” ХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Нако Түлш” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар
Ж.Энхцэцэгийг томилсугай.

1

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Б.БАТБААТАР



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 15 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 82

Багануур

Андеррайтер-зөвлөх компанитай байгуулсан гэрээг сунгах тухай

Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоол, “Багануур” ХК-ийн дүрмийн 10-р зүйлийн 10.3.20 дахь дэд заалт, Андеррайтер-зөвлөх компанитай байгуулсан гэрээг дүгнэсэн актыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Төрийн өмчийн хорооноос зохион байгуулсан “Багануур” ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах, хувьцааг олон нийтэд санал болгох замаар хөрөнгө босгох үйл ажиллагаанд Андеррайтер-Зөвлөх үйлчилгээ үзүүлэх компани шалгаруулах СШУ БНХК-2011-ЗҮ/01 тоот тендер шалгаруултанд оролцож шалгарсан “Ти Ди Би Капитал” ХХК-тай “Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Мэргэнбаатарын байгуулсан №12/02-419 тоот “Андеррайтер-зөвлөх үйлчилгээний гэрээ”-ний хугацаанд өөрчлөлт оруулан сунган батлахыг Гүйцэтгэх захирал (М.Отгонбаяр)-т зөвшөөрсүгэй.
2. Нэмэлт хувьцааг зохих хууль, журмын дагуу гаргах, холбогдох байгууллагуудад бүртгүүлэх, анхдагч зах зээл дээр нийтэд санал болгох замаар хөрөнгө босгох үйл ажиллагаа болон холбогдох гэрээ, хэлцэлд компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг гүйцэтгэх захирал (М.Отгонбаяр)-д олгосугай.
3. Энэхүү гэрээний биелэлт, ажлын явцын талаар сар тутам Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (М.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АРИУНБОЛД



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 15 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 33

Багануур

Хяналтын зөвлөл байгуулах тухай

“Багануур” ХК-ийн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.3.1 дэх заалт, “Багануур” ХК-ийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн сангийн журмын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн сангийн хуваарилалт, зарцуулалтад шинжилгээ хийж хяналт тавих эрх бүхий Хяналтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

ТУЗ-ийн Аудитын хорооны дарга Г.Ёндонгомбо

Гишүүд:

ТУЗ-ийн гишүүн Г.Мэргэнбаяр

“Багануур” ХК-ийн Хөгжил, нийгмийн асуудал эрхэлсэн дэд захирал

“Багануур” ХК-ийн Дотоод хяналт шалгалтын албаны дарга

“Багануур” ХК-ийн Үйлчилгээний автомашины хэсгийн жолооч Н.Цагаанхүү

2. Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын ажлын тайланг хагас жил тутам Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж байхыг Хяналтын зөвлөл /Г.Ёндонгомбо/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АРИУНБОЛД



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

20 15 оны 10 сарын 22 өдөр

Дүгээр 31

Багануур

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг
чөлөөлөх, томилох тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь.

1. “Багануур” ХК-ийн нийт хувьцааны 21.06 хувь буюу 4,416,668 ширхэг энгийн хувьцааг эзэмшигч “Монголиан нэшнл коал корпорэйшн” ХХК-ийн ирүүлсэн албан хүсэлтийн дагуу Г. Батдорж, О.Болор-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2. “Монголиан нэшнл коал корпорэйшн” ХХК-ийн ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Д.Цэрэнбадам болон О.Банзрагч нарыг түр томилсугай.

ДАРГА



Б.АРИУНБОЛД



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 50

Багануур

**Хөнгөлөлттэй үнээр нүүрс
олгох тухай**

Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3.20 дахь заалт, Компанийн 2014-2018 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр, Багануур дүүргийн Засаг даргын 2015 оны 09-р сарын 23-ны өдрийн 2/159 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн нийгмийн хариуцлагын стратегийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Багануур дүүргийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой айл өрхүүдэд олгох нүүрсний хэмжээг 1000 /нэг мянга/ тонн байхаар, 1 тонн нүүрсийг “ЭХЗХ”-оос тогтоосон дулааны цахилгаан станцуудад нийлүүлдэг нүүрсний үнээр олгохыг Гүйцэтгэх захирал /М.Отгонбаяр/-т зөвшөөрсүгэй.
2. Дүүргийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой айл өрхүүдэд нүүрс олгох ажлыг Багануур дүүргийн засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /М.Отгонбаяр/-т даалгасугай.
3. Энэхүү тогтоолыг 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Б.АРИУНБОЛД



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

15 оны 09 сарын 28 өдөр

Дуусгал 27

Багануур

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
зарлан хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн 27 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2015 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, “Багануур” ХК-ийн төлөөлөгчийн газрын хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.
 - Компанийн дүрмийн 8.1 дүгээр зүйлд Зарласан хувьцааны тоог 30,844,647 ширхэг болгох өөрчлөлтийг оруулах тухай;
 - Компанийн дүрмийн 10.3.14 дэх Компанийн шинээр худалдаж авах болон ашиглалтаас хасах, акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах гэсэн заалтыг толгой компаниас ирүүлсэн удирдамжийг үндэслэн компанийн ТУЗ шийдвэрлэнэ, гэж өөрчлөн найруулах тухай;
 - Компанийн дүрмийн 13.6.3, 13.6.4 дүгээр заалтуудыг хасах тухай
 - “Багануур” ХК-ийн зарласан хувьцаанаас 9,870,287 ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээлд нэмэлтээр гаргаж нийтэд худалдах тухай;
 - Шинээр нийтэд худалдахаар гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх шаардлагагүй гэж үзэх тухай;
 - Шинээр хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон худалдах хувьцааны санал болгох нэгж үнийг тогтоох эрхийг ТУЗ-д олгох зэрэг болно.
3. Санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдрийг 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрөөр, санал авах, хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2015 оны 11 дугаар сарын 5-ны өдрөөр тогтоосугай.
5. Хуралд бэлтгэх зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.
Үүнд:

Хуралд бэлтгэх зохион байгуулах комиссын дарга:

Т.Батбаяр /ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга/

Гишүүд:

Д.Ганчимэг /Хуулийн зөвлөх /

